



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/С05

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер
хүчингүй болгож шууд гэрээ байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 88 дугаар дүгнэлтийн дагуу Боловсрол, соёл, спортын салбарын их засвар, тоног төхөөрөмж (Өвөрхангай) ажлын 13 дугаар багц Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засвар (Өвөрхангай, Хайрхандулаан) багцыг 74323000 (далан дөрвөн сая гурван зуун хорин гурван мянга) төгрөгөөр Шилүүстэй хайрхан ХХК -иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Нэг ч үнийн санал ирүүлээгүй 8 дугаар багц Ерөнхий боловсролын сургуулийн барилгын их засвар (Өвөрхангай Гучин-Ус сум), 18 дугаар багц 1 дүгээр цэцэрлэгийн агааржуулалт засвар (Өвөрхангай Богд сум) багцуудыг хүчингүй болгож шууд гэрээ байгуулсугай.

3. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т тус тус даалгасугай.

4. Гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100884

D:My Doc. Zahiramj. Zasag darga